

**“САВ, БАГЛАА БООДОЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

№	Хөтөлбөрийн агуулга		Гүйцэтгэл		
1.	“Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2016оны 287 дугаар тогтоол		Зорилго: Сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх хууль, эрх зүйн болон бизнесийн таатай орчныг бүрдүүлж, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөтэй зориулалтын бус сав, баглаа боодлын хэрэглээг бууруулах		
2.	Санхүүжилтийн эх үүсвэр		Улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын санхүүжилт		
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа		Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хугацаа: 2016-2021 он Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хүрээлэн, Аймаг, нийслэлийн ХХААГ		
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		Зорилт 1. Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд ээлтэй сав, баглаа боодлын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг дэмжсэн хууль, эрх зүйн болон бизнесийн таатай таатай орчныг бүрдүүлэх; Зорилт 2. Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах; Зорилт 3. Сав, баглаа боодлын үндэсний үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хангамжийг нэмэгдүүлэх.		
5.	Үзүүлэлт	Төсөв (Нийт шаардагдах зардал)	Шаардагдах төслийн урьдчилсан тооцоолол байхгүй. Зарцуулсан төсвийн хөрөнгө: “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлсэн таван жилийн хугацаанд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцаас 2016 онд 9,900.0; 2017 онд 15,086.7; 2020 онд 9,000.0 нийт 33,986.7 мянган төгрөг зарцуулсан. 2018,2019, 2020-2021 онд улсын төсвийн хөрөнгө хуваарилаагүй.		
		Үүнд:	Төсөв (2021 он)	Гүйцэтгэл	Хувь
		Сая төг	0	0	0
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:		Арга хэмжээний биелэлт		
	Зорилт 1.		Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаас үзнэ үү.		
	Зорилт 2.		Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаас үзнэ үү.		
	Зорилт 3.		Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангаас үзнэ үү.		
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)		Дүгнэлт: 1. Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоол, “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний 2021 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн 90.34 хувь байгаа нь "бүрэн хэрэгжсэн"-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан гэж дүгнэхэд хүргэж байна. 2. Стратегийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээ нь 87.5 хувь байгаа нь хангалттай үзүүлэлт болно. 3. 2016-2021 онд хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулсан төсвийн хөрөнгө нь хангалттай хэмжээнд хүрээгүй. Зөвлөмж: “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрөөр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хөгжлийн зорилтот хөтөлбөрт тусгах нь зүйтэй		
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд		Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ холбогдох яамд, төрийн байгууллага, ХААДС, дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрүүд, олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, хэвлэл, мэдээллийн байгууллагууд, аймгуудын ХХААГ, холбогдох эрдэм		

	өгөх хөндлөнгийн үнэлгээ	шинжилгээний байгууллагуудтай хамтран хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар хангалттай сайн ажилласан гэж дүгнэж байна.			
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Дундаж үнэлгээ	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
	Хяналт-шинжилгээ, үнэлгээ (Зорилт, арга хэмжээний үнэлгээ)				
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ			
		... %			

ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт /2016/	Хүрэх түвшин /2021/	Хүрсэн түвшин /2021/	Үнэлгээ
1	Нэг өрхийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээ хадгалдаг зориулалтын бус хуванцар савны тоо	ширхэг	3-4	1-2	-25	50
2	Хуванцар савны олон улсын ангиллын тэмдэглэгээ, эрүүл мэндийн нөлөөлөл, зохистой хэрэглээний талаарх мэдлэг бүхий хэрэглэгч	хувь	22	50.0	25	50
3	Сав, баглаа боодол, хаяг шошгын дотоодын үйлдвэрлэлийн зах зээлд эзлэх хувь	хувь	30.0	50.0	20	100
4	Хүнд даацын уутны дотоодын үйлдвэрлэлийн зах зээлд эзлэх хувь	хувь	60.0	100	100	100
	Дундаж					87.5

САВ, БАГЛАА БООДОЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

2021 оны жилийн эцэс

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2021 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
1. Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд ээлтэй сав, баглаа боодлын үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг дэмжсэн хууль, эрх зүйн болон бизнесийн таатай таатай орчныг бүрдүүлэх						
1	1.1. Сав, баглаа боодол, хаяг шошго үйлдвэрлэх, тэдгээрийн хаягдлыг дахин боловсруулах зориулалт бүхий үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлэх;	2017 - 2021			Засгийн газрын 2017 оны 168 дугаар тогтоолоор “Гаалийн албан татвараас чөлөөлөх жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалт”-ыг батлуулсан. Уг тогтоолын хүрээнд сав баглаа боодол, савлах үйлдвэрийн нийт 27 тоног төхөөрөмж, хэрэгсэл 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлөгдсөн. Тус тогтоолын үйлчлэлийн хугацааг сунгуулах саналыг боловсруулан, Сангийн яам болон гаалийн тарифын зөвлөлд хүргүүлсэн боловч СЯ-аас тусгай зохицуулсан хууль эрх зүйн үндэслэлгүй тул үйлчлэлийн хугацааг сунгах боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн. Жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай тоног төхөөрөмжийг Гаалийн болон Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн боловч Татварын багц хууль батлагдсантай холбогдуулан татварыг давхардуулан ногдуулах боломжгүй гэсэн хариу өгсөн.	100%
2	1.2. Сав, баглаа боодол, хаяг шошгын үйлдвэрлэл, импорт, худалдаа болон хуучин савны устгал, шилжилтийг хянах, бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;	2017 - 2021			Мэдээллийн сангийн өгөгдөлтэй холбоотой дараах ажлыг хийж гүйцэтгэв: 1. Улаанбаатар хотод 17802 өрх, Дархан-Уул аймгийн 2197 өрхийн хуванцар савны хэрэглээний судалгаа, Хэнтий аймагт хүнсний зориулалтын сав баглаа боодлын үйлдвэрлэл эрхэлж буй ААН-ийн судалгаа, Төв аймагт 77 үйлдвэр, цех, 34 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулсан сав баглаа боодлын хэрэгцээ, шаардлагын судалгааг тус тус хийв. 2. Монголын Хүнсчдийн Холбоо нь ХХААХҮЯ-тай байгуулсан гэрээний дагуу 2021 онд 21 аймаг, Улаанбаатар хотын 4,472 өрхийг хамруулан, SPSS программ ашиглан зориулалтын бус химийн савны хэрэглээний түвшинг тогтоох судалгааг гүйцэтгэж, судалгааны тайланг хүлээлгэн өгсөн. 3. Сав баглаа боодлын худалдаа эрхлэгчдийн мэдээллийг бүртгэлжүүлэх ажлын хүрээнд Баян-Өлгий аймагт импортлогч 41 ААН, худалдаалагч 52 иргэн, Увс аймагт худалдаалагч 9 ААН-ийг бүртгэлжүүлсэн. 4. Архангай, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Ховд, Дундговь, Сүхбаатар, Завхан, Хэнтий, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, Дорнод аймагт хүнсний зориулалтын сав олгон, зориулалтын бус хуванцар сав, нийлэг хальсан уутыг устгалын	90%

					комисст хүргүүлэх, устгалд оруулах, сав баглаа боодлын хаягдлыг цуглуулан зохион байгуулалттайгаар УБ хот руу нийлүүлэх, модон торх, зэс, цайран шанага зэрэг эко савны хэрэглээг дэмжих, ургамал хамгааллын бодис, бордоо нийлүүлэгч ААН-д химийн бордоо, бодис хор гербицидийн савыг буцаан тушаах ажлыг гэрээний үндсэн дээр тус тус хэрэгжүүлсэн.	
3	1.3. Хүнсний зориулалтын бус саван дээр анхааруулах тэмдэглэгээ тавьдаг болох эрх зүйн зохицуулалт бий болгох;	2017 - 2021	-		1. "Хүнсгүй хүрэлцэхэд аюулгүй" тэмдэг, Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцлийг хангах хөтөлбөр. 4-р хэсэг: Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл-ийн стандартын төслийг тус тус боловсруулсан. Төсөлд холбогдох байгууллагаас санал авч, СХЗГ-ын Хүнсний стандартчилалын Техникийн хорооны хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. СХЗГ-ын даргын 2020 оны 07 сарын 01-ний Т-27 тушаалаар "Хүнсгүй хүрэлцэхэд аюулгүй тэмдэг" MNS 6848:2020 Үндэсний стандарт, Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцлийг хангах хөтөлбөр. 4-р хэсэг: Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл MNS ISO TS 22002-4 : 2020 Үндэсний стандартыг тус тус батлуулсан. 2. "Хүнсний зориулалтын хуванцар гадаргууг үйлдвэрлэхэд зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар"-ын төслийг боловсруулав. ХХААХҮЯ-ны mofa.gov.mn албан ёсны цахим хуудаст байршуулж, олон нийтийн саналыг авч, тусган, төслийг хамтран батлах, санал авахаар Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газарт хүргүүлэв.	100%
4	1.4. Сав, баглаа боодол, хаяг шошгын үйлдвэрлэл, импорт, худалдаа, хэрэглээг хамарсан техникийн зохицуулалт гаргах, олон улсын стандартуудыг нутагшуулах, одоо мөрдөж байгаа стандартуудыг шинэчлэх;	2017 - 2021			1. "Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийг хангах хөтөлбөр. 4-р хэсэг: Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл", "Хүнсгүй хүрэлцэхэд аюулгүй" тэмдэг стандартын төслийг тус тус боловсруулан, СХЗГ-ын даргын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн Т-27 тушаалаар MNS ISO TS 22002-4:2020 "Хүнсний аюулгүй байдлын угтвар нөхцөлийг хангах хөтөлбөр. 4-р хэсэг: Хүнсний сав баглаа боодлын үйлдвэрлэл", MNS 6848:2020 "Хүнсгүй хүрэлцэхэд аюулгүй тэмдэг" стандартыг тус тус батлуулсан. 2. ХХААХҮЯ нь УМЭАЦТЛабораторитай 200619/226 дугаартай гэрээ байгуулан Европын холбооны хүнсгүй харьцах материалын аюулгүй байдлын шинжилгээний аргын EN 1186-1:2002 (WI=00194065), EN 1186-3:2002 (WI=00194067), EN 1186-9:2002 (WI=00194073) дугаартай 3 стандартын сорил, баталгаажуулалтыг гүйцэтгүүлэн, тайланг хүлээн авсан. 3. "Аюултай бус бүтээгдэхүүнийг савлах уян даацын шуудай" стандартын төслийг боловсруулан, холбогдох байгууллагаас санал авч, СХЗГ-ын Сав баглаа, боодол стандартчиллын техникийн хороо /ТХ-29/-ны 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн бөгөөд техникийн хорооны гишүүдээс гарсан саналыг тусган, батлахаар шийдвэрлэсэн. 4. "Хүнсний зориулалтын хуванцар материалын аюулгүй байдлын техникийн зохицуулалт"-ын төслийн хамрах хүрээ, үндсэн бүтцийг тодорхойлж, сав баглаа боодлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, үйлдвэрлэл эрхлэгчдээс санал авч, нэгтгэсэн. 5. "Хүнсний	100%

					зориулалтын хуванцар гадаргууг үйлдвэрлэхэд зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар”-ын төслийг 5 бүлгийн хүрээнд боловсруулан, холбогдох байгууллагаас санал авч, олон нийтийн саналыг тусгах зорилгоор ХХААХҮЯ-ны mofa.gov.mn цахим хуудаст 30 хоногийн хугацаатай байршуулсан. Төслийг хамтран батлах, санал авахаар Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газарт хүргүүлсэн.	
5	1.5. Улсын хилээр хүнсний зориулалтаар нэвтрүүлэхийг зөвшөөрсөн сав, баглаа боодол, ахуйн барааны жагсаалт гаргах, барааны ангиллын код тодорхойлох, батлуулах;	2017 - 2021			А. ЕХ-ны хүнстэй хүрэлцэх гадаргууны аюулгүй байдлын талаарх 1935/2004, 10/2011 тоот журам, 10/2011 тоот журмыг хэрэгжүүлэх зааврыг тус тус судлан "Хүнстэй хүрэлцэх хуванцар гадаргууг үйлдвэрлэхэд ашиглахыг зөвшөөрсөн бодисын жагсаалт болон шилжилтийн зөвшөөрөгдөх хэмжээ"-г тогтоосон Үндэсний стандартын төслийг боловсруулав. Б."Хүнстэй хүрэлцэх хуванцар гадаргууг үйлдвэрлэхэд ашиглахыг зөвшөөрсөн бодисын жагсаалт болон шилжилтийн зөвшөөрөгдөх хэмжээ"-г тогтоосон Үндэсний стандартын төсөлд Монголын сав баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо, Ногоон титэм ХХК, ОБ пластик ХХК-иас санал авч тусгав. В. Стандартын төслийг СХЗГ-ын Хүнсний стандартчилалын Техникийн хороонд хүргүүлэв. Г. Хүнстэй хүрэлцэх гадаргаас хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын төрөл, тоо хэмжээг тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тодорхойлж, тогтооход хүндрэлтэй тул тэдгээрийг орлуулах загвар орчныг сонгоход баримтлах Үндэсний стандартын төслийг боловсруулж, СХЗГ-ын Хүнсний стандартчилалын техникийн хороонд албан тоотой хүргүүлсэн.	70%
6	1.6. Сав, баглаа, боодлын аюулгүй байдлыг хангах, хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламжийн хөрөнгийг уг салбарт зарцуулахыг дэмжих.	2017 - 2021			Монгол улс жилдээ 550 гаруй тэрбум төгрөгийн сав, баглаа боодлын хэрэгцээ шаардлага байдгаас 65 орчим хувийг импортоор, 35 гаруй хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна. Импортын сав, баглаа боодлын бүтээгдэхүүний 90 гаруй хувь нь БНХАУ-аас, үлдсэн хувийг ОХУ болон өөр бусад улс орнуудаас худалдан авч байна. АХБ-ны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт” төсөл, "Адра-Монгол" ОУБ, “Дэлхийн зөн- Монгол” ОУБ, НҮБ-ын ХХААБ-ын “SECIM” төсөл, Канад сан, GIZ-ийн ЭТИС төсөл, Францын хүнсний тусламжын сан зэрэг 10-аад олон улсын байгууллагын хөтөлбөр, төслийн хүрээнд хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр хамтран ажилласан.	50%
2. Хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах						
7	2.1. Хүнсний сүлжээний бүх үе шатанд ашиглах сав,	2017 - 2021			1. Хяналт шалгалтаар илрүүлсэн ХАБ-тай холбоотой зөрчлийн 12.2%-ийг сав баглаа боодол, шошготой холбоотой зөрчил эзэлж байгаа бөгөөд нийт сав баглаа боодол, шошгын зөрчлийн 72%-ийг арилгуулсан байна. 2.Хуванцар сав, баглаа боодлын нийт 3058 хүнсний чиглэлийн	100%

	баглаа боодол болон хүнстэй шууд харьцах үйлдвэрийн болон ахуйн хэрэгслийн аюулгүй байдлыг хангах, хаяг, шошгын зөрчлийг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх, уг үйл ажиллагаанд тавих төрийн болон дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх;			үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад МХЕГ-аас шалгалт хийхэд 1829 зөрчил илэрч, эдгээрийн 54.4%-ийг газар дээр нь арилгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, нийт 320 хуванцар савны дээжийг хими, нян судлалын лабораторийн шинжилгээнд хамруулан чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй 17 нэр төрлийн 1434 ширхэг зориулалтын бус хуванцар савыг хэрэглээнээс хасуулж, улсын байцаагчийн 49 акт үйлдэн, зөрчил арилгуулах 210 заалт бүхий 136 албан шаардлага өгч, 75165 ш хориглосон нэг удаагийн нийлэг уутыг улсын байцаагчийн 72 актаар хураан авч орон тооны бус комисст шилжүүлсэн байна. 3. "Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай" Засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоолын хэрэгжилтэд үнэлгээ өгөх зорилгоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 8200 газрын бүх төрлийн 0.035 мм болон түүнээс нимгэн, нэг удаагийн нийлэг хальсан уутны хэрэглээнд хяналт, шалгалт хийхсэн ба 5259 буюу 46%-ийг газар дээр нь арилгуулж, зөрчлийг арилгуулахаар 2885 заалттай 554 албан шаардлага хүргүүлж, тогтоолын хэрэгжилт 75.5%-тай байгааг тогтоосон . 4.Тогтоолыг хэрэгжүүлэх талаар хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид болон иргэдэд сургалтыг 1734 удаа 7972 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 1066 зөвлөмжийг 4669 хүнд хүргэж, 60 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, ажлыг хийсэн байна.	
8	2.2. Сав, баглаа боодлын аюулгүй байдлыг хангах, хаяг шошгын бичлэг үнэн зөв эсэхийг баталгаажуулдаг болох, үйлдвэрийн өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр түншлэгч орнууд, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагатай хамтарсан төсөл	2017 - 2021		1.Сав, баглаа боодол үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гадны буцалтгүй тусламж, хөрөнгө оруулалт татах зорилгоор 2017.11.21-ний өдөр гадаадын донор, олон улсын байгууллагын 100 гаруй төлөөлөгчдийг оролцуулсан зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, 5 төслийг танилцуулсан. 2.ЭМСайдын 2019 оны А/328, НЭМҮТ-ийн Ерөнхий захирлын 2019 оны А/94 дугаар тушаалаар Хүнсний сав баглаа боодол, шошгын орон тооны бус Зөвлөлийг 15 шинжээчийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, үйл ажиллагааны журам, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав баглаа боодол шошгод үнэлгээ хийсэн шинжээчийн дүгнэлт гаргах загвар маягтыг тус тус баталсан. 3. АХБ-ны 2025 он хүртэл хэрэгжих зээл, буцалтгүй тусламжийн жагсаалтад "Хүнсний сав баглаа боодлын аюулгүй байдлыг хангах" талаар төсөл хэрэгжүүлэх саналыг боловсруулж, хэлэлцүүлсэн. 4. Европын сэргээн босголт хөгжлийн банкны “Жижиг, дунд бизнесийн хөгжлийг дэмжих баг”-тай хамтран 2020.10.07-ны өдөр “Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зөвлөгөөн”-ий хүрээнд зохион байгуулсан хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлыг сайжруулах, олон улсын сайн туршлагыг нутагшуулах сургалт, хэлэлцүүлэгт 200 аж ахуйн нэгжийг хамруулсан. 5. АХБ-ны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт” төсөл, "Адра-Монгол" ОУБ, “Дэлхийн зөн- Монгол” ОУБ, НҮБ-ын ХХААБ-ын “SECIM” төсөл, “Зах зээл,	90%

	хэрэгжүүлж, олон улсын сайн туршлагыг нутагшуулах;				бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөл, Канад сан, GIZ-ийн ЭТИС төсөл, Францын хүнсний тусламжийн сан зэрэг 10-аад олон улсын байгууллагын хөтөлбөр, төсөлтэй хамтран сав, баглаа, боодлын аюулгүй байдал, зохистой хэрэглээний талаарх 15 гаруй удаагийн сургалтыг Баян-Өлгий, Говь-Алтай, Хэнтий, Төв аймгийн 1500 гаруй иргэн ААН-ийг хамруулан зохион байгуулсан. 6. Хөвсгөл аймагт НҮБ-ын ХХААБ-ын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”, Ногоон алт төслийн дэмжлэгтэйгээр сүү, цагаан идээ үйлдвэрлэж байгаа хоршоодод хүнсний зориулалт бүхий сав баглааг хэрэглэх, бүтээгдэхүүний хаяг шошгыг стандартын шаардлагад нийцүүлэн хэвлүүлж хэрэглэх талаар гарын авлага, зөвлөмж боловсруулан тараасан.	
9	2.3. Хоолны үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглаж байгаа картонон хайрцаг, нэг удаагийн хэрэглээний хэрэгсэл болон ус, ундааны хуванцар савны ариун цэвэр, эрүүл ахуйн байдлын талаар тандан судалгаа явуулж дүнг нийтэд мэдээлэх;	2017 - 2021			Монгол улсын хүн амын ахуйн хэрэглээнд ашиглаж буй хүнсний бус зориулалтын савны хэрэглээний түвшинг тогтоох судалгааг “Монголын хүнсчдийн холбоо” төрийн бус байгууллага гүйцэтгүүлэхээр 201110/07/470 дугаартай гэрээг байгуулж, дараах үр дүнд хүрсэн: I. Химийн бодисын хуванцар сав (пестицидийн цэнхэр сав, барилгын материал, замасканы сав, малын эм, бэлдмэлийн сав)-ны ахуйн хэрэглээний түвшинг тогтоох судалгааг Googleform судалгааны программ хангамжийг ашиглан цахимаар гүйцэтгэх аргачлалыг боловсруулсан. II. Химийн бодисын хуванцар савны ахуйн хэрэглээний түвшинг тогтоох судалгааг асуумжийн дагуу 21 аймаг, Улаанбаатар хотын судалгаанд хамрагдах өрхийн тоог 1%-иар тооцож, 4,472 өрхийг судалгаанд хамруулж, үр дүнг SPSS программ ашиглан боловсруулсан. III. Судалгаанд хамрагдсан өрхийн шинж байдал, хүнсний зориулалтын савны хэрэглээний түвшин, хүнсний зориулалтын савны тухай мэдлэг, ойлголт, зориулалтын бус хуванцар савны хэрэглээний сөрөг нөлөөний талаарх мэдээлэл авдаг эх сурвалж, хүнсний зориулалтын хуванцар савны хэрэглээг бууруулах боломж арга зам, устгал гэсэн 6 үндсэн сэдвийн хүрээнд мэдээллийг бэлтгэсэн. Зориулалтын бус химийн савны хэрэглээний түвшинг бодитой тодорхойлсон. -Хоол үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээнд хэрэглэж буй хуванцар сав, баглаа боодлын чанар, аюулгүй байдалд 2020 онд хийгдсэн урьдчилан сэргийлэх шалгалтаар хуванцар сав, баглаа боодлын нийт 3058 хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад шалгалт хийхэд 1829 зөрчил илэрч, эдгээрийн 54.4%-ийг газар дээр нь арилгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, нийт 320 хуванцар савны дээжийг хими, нян судлалын лабораторийн шинжилгээнд хамруулан чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй 17 нэр төрлийн 1434 ширхэг зориулалтын бус хуванцар савыг хэрэглээнээс хасуулж, улсын байцаагчийн 49 акт үйлдэн, зөрчил арилгуулах 210 заалт бүхий 136 албан шаардлага өгч, 75165 ш хориглосон нэг удаагийн нийлэг уутыг улсын байцаагчийн 72 актаар хураан авч орон тооны бус комисст шилжүүлсэн байна. /МХЕГ/	100%
10	2.4. Эмзэг бүтээгдэхүүн	2017 - 2021			1/ Ховд аймгийн Жаргалант суманд төсвийн хөрөнгөөр төмс, хүнсний ногооны механикжсан 1000 тонн багтаамжтай агуулах, зоорийг 2020 оны 10 дугаар сард ашиглалтад оруулсан. 2/	50%

	тээвэрлэх, хадгалах зориулалтын хөргөлттэй вагон, үр тарианы контейнер, автотээврийн хэрэгсэл, агуулах, зоорь, хөргүүрийн камерын хангамжийг нэмэгдүүлэхэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг чиглүүлж өргөжүүлэх;			“Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед хүнс болон нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх, түгээхэд баримтлах түр журам”-ын төслийг боловсруулж, батлуулсан. Тээвэр зуучийн мэдээллийн удирдлагын нэгдсэн систем www.teeverzuuch.mn -д түргэн гэмтэж муудах хүнсний бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд зохицуулалтыг тусгаж өгөв. Онцгой нөхцөл байдлын үед хүнс, нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүнийг хот доторхи, хот хооронд, импорт экспортын авто тээврээр тээвэрлэхэд батлагдсан түр журмын хүрээнд QR код ашиглан шуурхай зохион байгуулж байна. Мөн коронавируст халдварын цар тахлын үед хүнсний хангамж, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Мал, мах, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийг хот хооронд тээвэрлэх ажлыг зохион байгуулах тухай” хамтарсан тушаалын төслийг боловсруулж, батлуулсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 3/ Тээвэр зуучийн мэдээллийн удирдлагын нэгдсэн системд ачаа илгээгч болон хүлээн авагч, тээвэрлэгчийн ачааны мэдээллийг Барааг тодорхойлох кодлох уялдуулсан системийг ашиглан гүйцэтгэх талаар санал боловсруулж систем эзэмшигчид хүргүүлсэн болно.	
11	2.5. Түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодлын уян хатан, бат бөх чанар, найрлагыг судлах, тэмдэглэгээг баталгаажуулах, чанар, эрүүл ахуйн үнэлгээ хийх лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авах;	2017 - 2021		1. “Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй” тэмдэг” стандартын төслийг боловсруулж, холбогдох байгууллагаас санал авсан. Үндэсний стандартын төслийг СХЗГ-ын Хүнсний стандартчилалын Техникийн хорооны хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. СХЗГ-ын даргын 2020 оны 07 сарын 01-ний Т-27 тушаалаар “Хүнстэй хүрэлцэхэд аюулгүй тэмдэг” MNS 6848:2020 Үндэсний стандартыг атлуулсан. СХЗГ-ын Үндэсний стандартын санд бүртгүүлсэн. Сонирхсон үйлдвэрлэгч, хэрэглэгч www.estandart.gov.mn цахим хуудсаар дамжуулан худалдан авах боломжийг хангасан. 2. “Хүнсний зориулалтын хуванцар гадаргууг үйлдвэрлэхэд зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар”-ын төслийг 2021.06.16-2021.07.16-ны хугацаанд ХХААХҮЯ-ны цахим хуудасны "Төсөл хэлэлцүүлэг" хэсгийн https://mofa.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/tosol2045.pdf холбоост байршуулж, олон нийтийн саналыг авав. 2) Хүнсний үйлдвэрийн БХЗГ-ын мэргэжилтнүүд, Монголын сав баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо болон "Ногоон титэм" ХХК, "SFCS" ХХК-иас саналыг 4 удаагийн танхимын болон цахим хэлэлцүүлэг хийх замаар авч, төсөлд тусгав. 3) “Хүнсний зориулалтын хуванцар гадаргууг үйлдвэрлэхэд зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар”-ын төслийг эцэслэн боловсруулж, санал авч, хамтран батлахаар Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газарт хүргүүлэв.	70%
12	2.6. Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын	2017 - 2021		А. Хүнстэй хүрэлцэх хуванцар гадаргуу (хүнсний сав баглаа боодол, хүнсний үйлдвэрийн хүнстэй шууд хүрэлцдэг тоног төхөөрөмж, хоолны аягта, таваг, халбага сэрээ гэх мэт)-г үйлдвэрлэхэд ашиглах химийн бодисын төрөл, тэдгээрийн хүнсэнд шилжих зөвшөөрөгдөх	70%

	лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэн, ажилтнуудыг чадавхжуулах зэрэг арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх;			дээд хэмжээг олон улсын түвшинд тодорхойлж буй туршлагыг судлан "Хүнстэй хүрэлцэх хуванцар гадаргууг үйлдвэрлэхэд ашиглахыг зөвшөөрсөн бодисын жагсаалт болон шилжилтийн зөвшөөрөгдөх хэмжээ"-ний Б. Үндэсний стандартын төслийг боловсруулж, СХЗГ-ын Хүнсний стандарчилалын техникийн хороонд цахимаар хүргүүлэв. В. Тэмдэглээгээгүй эсхүл 3 гэсэн тэмдэглэгээтэй винил/поливинил (V/PVC) агуулсан хуванцар материалаар хийгддэг хүнсний зориулалтын бус хөх савнаас хүнсэнд шилжих химийн бодисыг хүнс ус, тос гэх мэт загвар орчинд ацетил-трибутил-цитрат (Acetyl tributyl citrate, ATBC) болон диоктил-адипат (Diocetyl adipate, DOA) гэсэн 2 бодисоор төлөөлүүлж тодорхойлсон. Олон улсын судалгаа шинжилгээний аргуудаас норматив ишлэл болгон ИЛРҮҮЛЭХ болон БАТАЛГААЖУУЛАХ түвшний 2 арга зүйг боловсруулсан. - “Масс спектрометртэй хосолсон хийн хроматографийн скан хийх горимоор ацетил-трибутил-цитрат болон диоктил-адипатыг илрүүлэх арга”, - “Масс спектрометртэй хосолсон хийн хроматографийн сим горимоор ацетил-трибутил-цитрат болон диоктил-адипатыг баталгаажуулах арга”. Европын холбооны Хүнстэй харьцах материалын лавалгаа лабораторийн “Хүнсний бүтээгдэхүүнтэй харьцах материалын хяналтанд ашиглах шинжилгээний аргуудын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, баталгаажуулалтын удирдамжийн дагуу аргад баталгаажуулах үйл ажиллагааны схемийг боловсруулав	
13	2.7. Хүнсний сав, баглаа, боодлын худалдаа, хэрэглээний талаар хэрэглэгчдэд чиглэсэн зөвлөмж, зөвлөгөө, мэдээ мэдээлэл болон сэрэмжлүүлгийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх, сурталчлах;	2017 - 2021		Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын аюулгүй байдлыг сайжруулах, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөтэй зориулалтын бус сав, баглаа боодлын хэрэглээг бууруулах ажлын хүрээнд “Хөх сав, канистергүй аймаг, сум” хөдөлгөөнийг улсын хэмжээнд өрнүүлж, аймагт орон нутгийн ТВ, радио, цахим хуудсаар 163 удаагийн давтамжтай цахимаар, 19700 ширхэг сурталчилгааны материалыг давхацсан тоогоор 60240 иргэн, ААН-ийн төлөөлөлд хүргэсэн. Архангай аймагт “Хүнсний зориулалтын сав, баглаа боодол”, “Хуванцар савны хэрэглээ”, “Хүнсний аюулгүй байдлыг шалгаж, шошго уншиж сурцгаа” мэдээллийг байгууллагын болон нийгмийн цахим сүлжээнд байршуулж 130 хүнд хүргэсэн. “Зориулалтын бус хуванцар савнаас татгалзъя” гарын авлагыг иргэдэд тарааж, зөвлөгөө өгч, орон нутгийн хөгжлийн сангаас 2.8 сая төгрөгийн 100 ширхэг хүнсний зориулалтын савыг иргэдэд олгосон. Булган аймгийн 16 сум, 1 тосгоны 200 гаруй бизнес эрхлэгч, хоол үйлдвэрлэгч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, хүнсний зориулалтын хуванцар савны талаархи 3 гарын авлага материал тарааж, цахимаар 2 бичлэг, 4 төрлийн мэдээллийг сурталчилж ажилласан.	100%
14	2.8. Хүний эрүүл мэндэд хортой, сөрөг нөлөөтэй нь	2017 - 2021		1. Ургамал хамгааллын бодис импортлох тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж сав баглаа боодлоо зориулалтын дагуу устгуулсан тухай баримтыг ирүүлэх тухай заалтыг гэрээнд тусгаж, ирүүлсэн баримтыг үндэслэн дараагийн ургамал хамгааллын бодис импортлох тоо	100%

	тогтоогдсон хүнсний зориулалтын бус сав, баглаа боодол, хэрэгслийг хүнсний худалдаа, үйлчилгээ, нийтийн хоол, сургууль, цэцэрлэг, дотуур байр, эмнэлэг зэрэг газар хэрэглэхийг хориглох, өрхийн хэрэглээнээс халах арга хэмжээ авах;			хэмжээний зөвшөөрлийг олгож байна. 2. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 473, хүнсний үйлдвэр 141, хүнсний худалдааны 577, нийт 1191 аж ахуйн нэгж, иргэнийг шалгалтад хамруулж, 54 зөрчил илрүүлэн, 49 буюу 91 хувийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан. Улаанбаатар хотын хэмжээнд хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид хүнсний зориулалтын бус хуванцар сав, хэрэглэлийг ашиглах зөрчлийг бүрэн таслан зогсоож, Ерөнхий боловсролын сургуулийн 90 хувь хүнсний зориулалтын сав хэрэглэж байна. 3. Увс аймагт эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн гал тогооны сав суулга, түүхий эд бүтээгдэхүүн нийлүүлдэг аж ахуй нэгж 100 хувь хүнсний зориулалтын сав ашигладаг болгосон. -Хяргас, Зүүнхангай, Өлгий, Цагаанхайрхан зэрэг сумдын 85 малчин өрх хөхүүр хэрэглэж байна. Шинээр 20 өрх хөхүүр худалдан авсан. Сумдын хүнсий дэлгүүрүүд, СХСангаас зээл авсан иргэдтэй хамтарч, сумын хүнс барааны дэлгүүрүүдээр даавуун тор оёж борлуулах ажлыг эрчимжүүлж байна. Одоогийн байдлаар 6 сум даавуун тор оёж худалдаанд гаргаж байна.	
15	2.9. Хүнсний зах, худалдааны төв, үйлдвэр, үйлчилгээний газруудыг эрүүл ахуйн шаардлага хангасан стандартын тор, бидон, зориулалтын сав, баглаа боодол, агуулах, хөргүүр ашиглахыг шаардах, зөв дадлыг хэвшүүлэх;	2017 - 2021		Хүнсний зориулалтын бус буюу винил/поливинил агуулсан хуванцар материалаар хийсэн хуванцар сав (хөх сав)-ны 3 дээж, 5 гэсэн тэмдэглэгээтэй хүнсний зориулалтын савны 1 дээжийг сонгон авч, мөн хяналтаар хүнсийг оруулах 3 төрлийн орчинг бэлтгэн, шинжилгээнд хамруулав. Ацетил трибутил цитрат (Acetyl tributyl citrate, ATBC) болон диоктил адипат (Diocetyl adipate, DOA) зэрэг бодисыг илрүүлэх (Бүхлээр скандах /full scan/ аргаар шилжилтийн бодис илрүүлэх) болон баталгаажуулах, тоон шинжилгээний аргазүйн (Сим /Sim mode/ аргаар шилжилтийн бодис тодорхойлох) масс спектрометртэй хосолсон хийн хроматографийн багажинд калибровка, тохиргоо хийв. Боловсруулсан шинжилгээний аргыг Европын холбооны Хүнстэй харьцах материалын лавлагаа лабораторийн “Хүнсний бүтээгдэхүүнтэй харьцах материалын хяналтанд ашигласан шинжилгээний аргуудын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, баталгаажуулалтын удирдамжид заасан схемийн дагуу гурван төрлийн орлуулах орчинг ашиглан, аргын нарийвчлал, таарц, үнэн байдал, хэвийх утга, илрүүлэх доод хязгаар, тоон шинжилгээний доод хязгаар гэсэн шинжилгээний аргын 6 шалгуур үзүүлэлтээр баталгаажуулсан ба дээрх арга сав баглаа боодлын хяналтанд ашиглах шинжилгээний аргын шаардлагыг хангасан. Хөх сав буюу хүнсний зориулалтын бус сав баглаа боодлын 3 дээжинд 240 цагт бодисын нийт шилжилт 7-24 мг/л, ацетил трибутил цитратын хувийн шилжилт 0.04-0.15 мг/дм3 болон диоктил адипатын хувийн шилжилт дундажаар 0.15 мг/дм3 болохыг тогтоов. -Хүнсний чанар, стандартын хяналтын чиглэлээр мөрдөгдөж буй 20 хяналтын хуудсанд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах” хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүний эрүүд мэндэд сөрөг нөлөөгүй материалаар хийсэн хүнсний зориулалтын сав, баглаа боодолд	100%

					савласан байна” гэсэн асуулт бүх хяналтын хуудсуудад тусгагдаж жил бүр хяналт шалгалт хийж байна.	
16	2.10. Химийн бодисын хуванцар сав, торх, канистерыг хүнсний зориулалтаар ашиглуулахгүй байх зорилгоор “Шинэ санаа-шилдэг шийдэл” уралдаан зарлаж, дүнг нийтэд сурталчлах, түгээх;	2017 - 2021			1. Газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж буй ургамал хамгааллын бодис, бордооны ашиглалтад хяналт тавих “Ургамлын гарал үүсэл, пестицидийн бүртгэл мэдээллийн систем”-ийг хөгжүүлсэн. Импортлосон ургамал хамгааллын бодисын сав баглаа боодлыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр зориулалтын дагуу устгуулах тухай заалтыг гэрээнд тусгаж, заалтын хэрэгжилтэд үндэслэн дараагийн ургамал хамгааллын бодис импортлох тоо хэмжээний зөвшөөрлийг олгож байна. 2. Дархан-Уул Аймгийн Стандарт, Хэмжилзүйн Хэлтсийн дэргэдэх орон тооны бус баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар хүнсний зориулалтын сав, баглаа боодол, хэрэгсэл, хаяг, шошгын стандартын талаар 11 аж ахуйн нэгж байгууллагад сурталчилж, мэргэжил аргагүйн зөвлөгөөг өгч ажилласан Нэг суурин-Нэг бахархал аяны хүрээнд шилдэг сав баглаа боодол үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийг шалгаруулж урамшуулах арга хэмжээг зохион байгуулж, 3 аж ахуйн нэгж сав баглаа боодлын шалгаруулалтад материалаа ирүүлээд байна. Хөгжлийн Шийдэл ОУБ-ын Best хөтөлбөр, Эко ноос ХХК хамтран “Малчдын хоршоо-Үндэсний үйлдвэр түүхий бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт” сургалтад малчин хоршоодын 33 төлөөлөлд зориулалтын бус савнаас татгалзах хөх савны хор хөнөөлийг сурталчиллаа.	70%
17	2.11. Хүнс үйлдвэрлэгчдэд хаяг шошгын стандарт мөрдүүлж хэвшүүлэх, хэрэглэгчдийг төөрөгдүүлэхээс сэргийлэх зорилгоор сурталчилгааны арга хэмжээ авах;	2017 - 2021			Өвөрхангай аймагт хүнсний бус хуванцар савны хор хөнөөл, түүний хэрэглээг бууруулах нөлөөллийн арга хэмжээг сум бүр зохион байгуулж, гарын авлага, зөвлөмж бэлтгэн, иргэдэд мэдээллэж ажилласан. Хяналт, шалгалт хийж, хүнсний зориулалтын сав хэрэглэх талаар 211 албан мэдэгдэл хүргэн, ус түгээх 63 цэгт хуванцар савны хэрэглээнээс татгалзахыг уриалсан зурагт хуудас байршуулсан байна. Бат-Өлзий сумын “Малчдын хамтын хүч” хоршоо “Савыг саваар солих” арга хэмжээ зохион байгуулж, гишүүн өрхдөө зориулалтын сав нийлүүлэн, зориулалтын бус саванд малын тэжээл даршлах арга зүйгээр хангаж, тэжээл бэлтгэсэн. Нийт 89 удаа цахим болон танхимын сургалт зохион байгуулан, давхардсан тоогоор 14408 иргэн, аж ахуйн нэгж хамрагдаж, 14589 ширхэг гарын авлага бэлтгэн сурталчилсан. Үүний үр дүнд 2102 айл өрх, 90 байгууллагын гал тогоо, 62 нийтийн хоолны газар хуванцар савнаас татгалзсан дүнтэй байна. Аймгийн хэмжээнд төсөвт байгууллагуудын гал тогоо зориулалтын бус хуванцар савыг 100 хувь хэрэглээнээс халсан. Мөн хуванцар савнаас татгалзсан малчин айл өрхүүдийн сайн туршлагын талаар видео бичлэг хийж, “Малчин” телевиз болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сайтуудаар улсын хэмжээнд сурталчилсан. “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөр болон дэд төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад орон нутгийн төсөв болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээс 44,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Дархан-Уул аймгийн хүнс үйлдвэрлэгч 47 ААН, 47 цехэд МХГ-ын төлөвлөгөөт хяналт шалгалт,	100%

					Стандарт, хэмжилзүйн хэлтсийн дэргэдэх орон тооны бус Баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар жил бүр хаяг шошгын стандартыг мөрдөж ажиллах талаар заавар зөвлөмж өгч, мөрдүүлж, хэвшүүлсэн. Хаяг шошгын стандарт хэрэгжилтийг ханган ажиллаж, тухай бүр зөрчлийг арилгуулсан. 2021 онд 17 ААН-ийн 13 төрлийн 82 бүтээгдэхүүнд зөвлөгөө өгч, үйлдвэрлэсэн огноог тогтмол бичих талаар зөвлөгөө өгсөн	
18	2.12. Зөв шошготой, чанар, стандартын шаардлага хангасан сав, баглаа боодлын талаар мэдээллийн сан бүрдүүлж, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд хүргэх ажлыг мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулах;	2017 - 2021			1.Өмнөговь аймгийн Есөнзүйл сум “Чиглэл” ХХК-тай гэрээ байгуулж, ЕБС, СӨБ-ын байгууллагын гал тогоог чанарын шаардлага хангасан 1.0 сая төгрөгийн үнэ бүхий цэвэр ган саваар хангасан. Нийт 89 удаа цахим болон танхимын сургалт зохион байгуулан, давхардсан тоогоор 14408 иргэн, аж ахуйн нэгж хамрагдаж, 14589 ширхэг гарын авлага бэлтгэн сурталчилсан. Үүний үр дүнд 2102 айл өрх, 90 байгууллагын гал тогоо, 62 нийтийн хоолны газар хуванцар савнаас татгалзсан 2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А-09, дугаар тушаалаар батлагдсан “Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам”, А-180 дугаар тушаалаар батлагдсан “Органик хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам”-ын дагуу органик хүнсний бүртгэл мэдээллийн сан www.organic.gov.mn –г ашиглаж байна. Санд техникийн сайжруулалт хийх, үйлдвэрлэл эрхлэгчдэд ашиглахад хялбар болгох ажлыг жилийн туршид зохион байгуулсан. Органик хүнсний баталгаажуулалтын 19 байгууллага /2019 онтой харьцуулахад 23.6%-иар өссөн/ нийт 708 га органик газарт тариалсан хүнсний ногоо, маллаж өсгөсөн мал, амьтны гаралтай 59 төрлийн 580 органик, шилжилтийн 110 хүнсийг баталгаажуулж, Органик хүнсний бүртгэл, мэдээллийн санд www.organic.gov.mn -д бүртгэж, нийтийн хэрэгцээнд гаргасан байна. Импортын 40 бүтээгдэхүүн бүртгэлтэй байна.	100%
19	2.13. Хүнсний зориулалтын бус хуванцар сав, гялгар уутны хэрэглээнээс татгалзах аян өрнүүлэх, “Хөх сав, канистергүй аймаг, дүүрэг, сум, хороо” хөдөлгөөн өрнүүлж, жил бүр дүгнэж мэдээлдэг болох;	2017 - 2021			Архангай, Өвөрхангай, Дундговь, Сүхбаатар, Орхон, Сэлэнгэ, Ховд, Завхан аймагт ЕБС, цэцэрлэгийн дэргэдэх гал тогоо, үдийн цайны газарт хуванцар савны хэрэглээг бүрэн зогсоож, худалдааны газраар худалдаалж буй хуванцар саванд хяналт шалгалт хийх, зориулалтын бус савыг худалдаанаас татан авах, зориулалтын саваар солих, тэмдэглэгээний талаар зөвлөмж өгөх, илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага, зөвлөмж хүргүүлж ажиллав. Орон нутгийн төсвийн хөрөнгө болон олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр Архангай, Орхон, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Өвөрхангай, Хэнтий, Говь-Алтай, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн 725 өрхөд 30-100% үнийн хөнгөлөлттэйгөөр савыг саваар солих ажлыг хийж гүйцэтгэсэн.Төв аймагт хөх савны хор уршгийн талаар 5124 гаруй малчдад мэдээлэл хүргэж, 153 уст цэгт зурагт хуудсыг байршуулж, хүнсний хэрэглээнд зориулалтын сав хэрэглэх талаар 2 удаагийн шторкийг ТBS, ТӨВ телевизээр олон нийтэд мэдээлэл хүргэж сурталчилсан.	100%

20	2.14. Хуванцар савны олон улсын ангиллын тэмдэглэгээг хэрэглээнд хэвшүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчлан таниулах арга хэмжээ авах;	2017 - 2021		А. ЕХ-ны хүнстэй хүрэлцэх гадаргууны аюулгүй байдлын талаарх 1935/2004, 10/2011 тоот журам, 10/2011 тоот журмыг хэрэгжүүлэх зааврыг тус тус судлан "Хүнстэй хүрэлцэх хуванцар гадаргууг үйлдвэрлэхэд ашиглахыг зөвшөөрсөн бодисын жагсаалт болон шилжилтийн зөвшөөрөгдөх хэмжээ"-г тогтоосон Үндэсний стандартын төслийг боловсруулав. Б."Хүнстэй хүрэлцэх хуванцар гадаргууг үйлдвэрлэхэд ашиглахыг зөвшөөрсөн бодисын жагсаалт болон шилжилтийн зөвшөөрөгдөх хэмжээ"-г тогтоосон Үндэсний стандартын төсөлд Монголын сав баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо, Ногоон титэм ХХК, ОБ пластик ХХК-иас санал авч тусгав. В. Стандартын төслийг СХЗГ-ын Хүнсний стандартчилалын Техникийн хороонд хүргүүлэв. Г. Хүнстэй хүрэлцэх гадаргаас хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын төрөл, тоо хэмжээг тухайн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд тодорхойлж, тогтооход хүндрэлтэй тул тэдгээрийг орлуулах загвар орчныг сонгоход баримтлах Үндэсний стандартын төслийг боловсруулж, СХЗГ-ын Хүнсний стандартчилалын техникийн хороонд албан тоотоор хүргүүлсэн. Д. Орхон аймгийн "Усны зөн" ХХК-ий үйлдвэрлэсэн хүнсний зориулалтын 25, 40, 65 литрийн багтаамжтай 150 ширхэг хуванцар савыг Баян-Өндөр, Жаргалант сумын нийт 75 өрхөд үйлдвэрийн үнээс 20-30 хувийн хөнгөлөлттэй үнээр олгож, Хүлэг хүнсний захын сүү, цагаан идээ, жимс жимсгэнэ худалдан борлуулдаг худалдаа эрхлэгчдийг 100 хувь хүнсний зориулалтын саваар хангасан. Хүнсний зориулалтын хуванцар савны тэмдэг, тэмдэглэгээний талаарх Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас бэлтгэсэн зурагт хуудас, зөвлөмжийг байгууллагын болон Баян-Өндөр сум, Орхон аймгийн Хүнс, хоол, хүнсний худалдаа эрхлэгчдийн пэйж хуудсуудад шэйрлэхэд нийт 118 хүн үзэж, 32 хүн шэйрлэсэн байна. Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллага, хүнсний худалдаа эрхлэгч нийт 58 хүнд хүнсний зориулалтын сав баглаа, боодлын талаарх 3 төрлийн гарын авлагыг тараан сурталчилсан.	100%
21	2.15. Хүнсний чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулан сав, баглаа боодлын эрүүл ахуй, чанар стандарт, аюулгүй байдлын талаар тусгайлан сургалт зохион байгуулах;	2017 - 2021		1. “Хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодлын чанар, аюулгүй байдалд тавих хяналт” сургалтыг аймаг, нийслэлийн 120 улсын байцаагчдыг хамруулан цахимаар зохион байгуулж, хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг лабораторийн шинжилгээнд хэрхэн хамруулах, хяналт шалгалтын явцад шалгах асуудлууд, олон улсаас баримтлаж буй бодлого, хэрэгжилтийн талаар мэдлэг мэдээлэл олголоо. 2. Говь-Алтай аймагт Дэлхийн байгаль хамгаалах сангийн дэмжлэгээр Хөхморьт сумын иргэдэд хуванцар сав, гялгар уутны хор уршиг, түүнээс татгалзах сургалт зохион байгууллаа. Сургалтад тус сумын малчин өрх, 8-9 дүгээр ангийн сурагчид, бизнес эрхлэгчид зэрэг 350 гаруй иргэн хамрагдав. 3.Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай Засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоолын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 1734	100%

				иргэдийг хамруулан сургалт явуулж, 7972 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 1066 зөвлөмжийг 4669 хүнд хүргэж, 60 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулав. 4. Хууль тогтоомжийг сурталчлан таниулах, хориглосон нийлэг хальсан уут, түүний хор хөнөөлийн талаар 55 удаа телевизээр, 10 удаа радиогоор, 9 удаа сонингоор, 329 удаа байгууллагын веб сайт, фасебүүкэд байршуулсан бөгөөд 21 аймаг нийслэлийн МХГ-аас 22 шторм, 126 постерыг бэлтгэж олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг хийв. 5. Сэлэнгэ аймагт "Нэг удаагийн хальсан уутыг хориглох тухай"-хэрэгжилтэд хяналт тавьсан. Зөрчлийн 9 буюу 37%-ийг арилгуулж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.	
22	2.16. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн зөөвөрлөх, хадгалахад ашиглаж байгаа зориулалтын бус савыг зориулалтын саваар солих арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.	2017 - 2021		Засгийн газрын 2021.10.13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор баталсан "Сав баглаа боодол" үндэсний хөтөлбөрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх зорилгоор хүчингүй болсонд тооцсон тул тус хуулийн дагуу дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих “Хөгжлийн зорилтот хөтөлбөр”-үүдэд сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх хууль, эрх зүйн болон бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөтэй зориулалтын бус сав, баглаа боодлын хэрэглээг бууруулах, хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын аюулгүй байдлыг сайжруулах зэрэг зохицуулалтыг тусгуулан хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Баянхонгор аймгийн Өлзийт, Эрдэнэцогт, Баацагаан сумын 25 өрх 2 хоршоонд 325 ширхэг сүү сүүн бүтээгдэхүүний сав суулгыг төслийн хүрээнд олгосон. Хөвсгөл аймагт “Өрхийн хуванцар савны хэрэглээ” судалгааг 168 өрхөөс 4 асуумжаар авч нэгтгэн дүгнэхэд сургууль цэцэрлэг эмнэлгүүд зориулалтын бус хуванцар савыг 100% хэрэглээнээс хассан дүн гарсан. Дорноговь аймгийн 14 сумын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөр, хуванцар савны хэрэглээг бууруулах, хүнсний сав, баглаа, хаяг шошгоны стандарт, хуванцар савны эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө, хуванцар савны олон улсын тэмдэг, тэмдэглэгээ, эрүүл хүнсний савны талаарх сурталчилгаа, сургалт мэдээллийг зохион байгуулж нийт 432 хүн хамруулсан. Аймгийн Засаг даргын А/470 дугаар захирамжаар “Хөх сав, канистергүй аймаг, сум, баг, өрх” болох аяны хүрээнд орон нутгийн сургууль, цэцэрлэг, эмнэлгийн гал тогоо зориулалтын бус хуванцар савыг хэрэглээнээс халж, эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын савыг хэрэглэдэг болсон. Аймгийн төвийн 3000 гаруй өрхийн унд, усны савны хэрэглээний судалгаагаар нийт өрхийн 22,3% нь төмөр сав, 30,1% нь хуванцар сав, цаасан уут 2,08%, даавуун уутыг 5,2%, гялгар уут 40,3% нь ашиглаж байна.	70%
3. Сав, баглаа боодлын үндэсний үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хангамжийг нэмэгдүүлэх					
23	3.1. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд	2017 - 2021	3918.3 сая төгрөг	ЖДҮХС-аас 2017-2019 онуудад Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын иргэнд СББ-ын үйлдвэр байгуулах зориулалтаар 120 сая, УБ хотын хуванцар сав үйлдвэрлэгч Аргил сувд	100%

	ээлтэй, шинэ технологи бүхий сав, баглаа боодлын эко үйлдвэр байгуулах хувийн хэвшлийн санал, санаачилгыг дэмжих;		ЖДҮХС, ОНХС, СХС	ХХК, Дундговь аймгийн уламжлалт модон торх, сав үйлдвэрлэгч Тэббэ ХХК, Царамтайн Алтай ХХК-д нийт 2 тэрбум, Дорноговь аймгийн 2 ААН, Баян-Өлгий аймгийн даавуун болон цаасан уутны 1 ААН-д 35 сая, Говьсүмбэр аймгийн 1 иргэнд 20 сая, Увс аймгийн “хуванцар савгүй” цехийн төсөлд 40 сая, Өвөрхангай аймгийн хүнсний бүтээгдэхүүний СББ-ын төсөлд 40 сая, модон савны үйлдвэрлэлд 30 сая, Орхон аймгийн уламжлалт модон эдлэлийн үйлдвэрт 20 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгосон байна. ЗГ-ын 2020 оны 113 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд ХХААХҮСайдын 2020 оны А-131 дугаар тушаалаар батлагдсан ЖДҮХС-аас 2020 онд хөнгөлөлттэй зээл олгох салбар чиглэлд СББ үйлдвэрлэлийг оруулж, 7 ААН-д 1,060.2 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Мөн Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци цаасан сав баглаа боодлын үйлдвэрт 70 сая, Зуунмод сумын СХС-аас 2 ААН-д 30.5 сая, Дундговь аймгийн СХС-аас хүнсний цаасан тор, уут үйлдвэрлэгч иргэнд 30 сая, Дархан-Уул аймаг СХС-аас Бурхантын бүтээлч бүсгүйчүүд хоршооны даавуун тор, уутны үйлдвэрлэлд 15 сая, Ховд аймгийн Жаргалант сумын СХС-аас сав баглаа боодол үйлдвэрлэгч 1 иргэнд 10 сая, Төв аймагт тусгай сангуудаас сав, баглаа боодол, хаяг шошгын 10 иргэн, ААН-д нийт 165 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус олгосон. Өвөрхангай аймаг 2020 оныг “Өвөрхангайд үйлдвэрлэв” жил болгон зарласантай холбогдуулан 14 иргэн, ААН-д сав баглаа боодлоо шинэчлэхэд зориулан 38 сая, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээс 74.6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. “Шинэ хөдөө Булган” төслөөс сүүний хөргүүртэй контейнерт сүү зөөвөрлөх зориулалт бүхий 35 ширхэг 40 литрийн бидоныг олгосон. Сүхбаатар аймагт “Тэнүүн билиг арвижих” ХХК нь 120 сая төгрөгийн өөрийн санхүүжилтээр 40000 шир/сар цаасан уут үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийг байгуулж, 3 хүнийг ажлын байраар хангасан.	
24	3.2. Уламжлалт модон торх, ган, хувин, ширэн хөхүүр, гоёл чимэглэлийн уут, савны урлалыг дэмжиж брэнд болгох ажлыг орон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан зохион байгуулах, даавуун болон цаасан тор,	2017 - 2021	326.3 сая төгрөг ОНХС, СХС, ОУБ	Дундговь аймгийн уламжлалт модон хувин, торхны ТЭББЭ ХХК ЖДҮХС-аас 300 сая төгрөгийн зээл авч, хүчин чадлаа 35% нэмэгдүүлэн, 4 аймагт борлуулалтын цэгээ нээсэн. Мөн тус аймгийн 5 иргэн захиалгаар уут, тор, 28ш хөхүүр, 50л-1 тн багтаамжтай 23ш төмөр хувин үйлдвэрлэн иргэдэд нийлүүлсэн байна. Төв аймгийн тусгай сангуудаас 9 сумын 11 цехд 195 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 214ш торх, 112ш хөхүүр, 58ш домбо, 3950ш даавуун болон цаасан тор үйлдвэрлэн зах зээлд нийлүүлсэн байна. Мөн уламжлалт торх, хувин, хөхүүр, уут, савны үйлдвэрлэлийг дэмжин СХС-аас Хөвсгөл аймгийн 2 иргэнд 30 сая, Хэнтий аймгийн 7 иргэнд 25 сая, Орхон аймгийн 1 ААН-д 20 сая, Говь-Алтай аймгийн 1 ААН-д 13 сая, Архангай аймгийн 1 иргэнд 1 сая төгрөгийн зээлийг тус тус олгосон. Дархан-Уул аймгийн СХС-аас Бурхантын бүтээлч бүсгүйчүүд хоршоонд 15 сая зээл олгон, ЗДТГ, Глобол коммуникэйшн ОУБ-ын захиалгаар 3.5 сая төгрөгийн уут оёулж, 5 багийн 45 иргэнд олгосон. Тус аймагт шуудайн 1, цаасан уут, хаяг шошгын 7 үйлдвэр, оёдлын 1 хоршоо уут, тор үйлдвэрлэн зах	100%

	уутны хэрэглээг дэмжих;				зээлд нийлүүлж байна. Хэнтий аймгийн 2 суманд “Цаасан болон давуун торыг ашиглацгаа” уриалга гарган, түргэн хоолны газар, хүнсний дэлгүүрүүд цаасан болон даавуун тороор үйлчилж байна. Сэлэнгэ аймагт “Даавуун уутны бүтээлийн уралдаан” зарлаж, 17 сумын 100 гаруй бүтээл ирүүлснээс эхний 3 байрт шалгарсан оролцогчид бүтээгдэхүүнээ аймгийн томоохон худалдаа, үйлчилгээний газруудаар худалдаалан 23.5 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Сүхбаатар аймагт “Мөнгөн богц” уралдаан зарлаж, 3 сумын 20 гаруй бүтээл ирснийг шалгаруулан, 2 сумын 3 ААН, иргэнийг 300 мян.төгрөгөөр шагнаж урамшуулсан. Баян-Өлгий аймагт “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” аяны хүрээнд 2021.11.12-ны өдөр Брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн талаарх сургалт зохион байгуулж, сав баглаа боодлын Мон-Алтай ХХК, оёдлын Алтайн оймс ХХК-иуд брэнд бүтсэн түүхээ хуваалцлаа. Аймгууд орон нутгийн онцлогийг шингээсэн брэнд бүтээгдэхүүний бэлгийн багц гаргаж, аймгийн томоохон дэлгүүрүүдээр худалдаалж байна.	
25	3.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд чанар, стандарт, загвар дизайны шаардлага хангасан дотоодын сав, баглаа боодол, хаяг шошго хэрэглэхийг төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд уриалж, энэ чиглэлээр явуулж байгаа сурталчилгаа, маркетингийн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;	2017 - 2021			“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Оюу толгой” ХХК-иуд даацын шуудайн Цасода пластик ХХК, Минерал байг ХХК, Их шанхын дугант ХХК, Шинэ гантиг ХХК зэрэг үйлдвэрүүдтэй ханган нийлүүлэлт хийх гэрээ байгуулан ажиллаж байна. "Таван толгой түлш" ХХК шахмал түлш савлах 2 сая.ш 25 кг-ийн шуудайг дотоодын үйлдвэрээс худалдан авахаар СББ үйлдвэрлэгчдээс санал авч байна. Өвөрхангай аймагт "Орон нутгийн үйлдвэрлэл-борлуулалтыг дэмжье 2020" аян зохион байгуулж, дотоодын СББ хэрэглэхийг уриалан, сурталчилсны дүнд төсвийн 1.4 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Төв аймагт төсвийн худалдан авалтаар 204 ААН, иргэнээс 684 сая төгрөгийн стандартын шаардлага хангасан сав баглаатай бараа бүтээгдэхүүн худалдан авсан. Хэнтий, Булган аймагт стандартын шаардлага хангасан СББ хэрэглэхийг уриалж, сурталчлан, “Хэнтийд үйлдвэрлэв” хүнсний бүтээгдэхүүний бэлгийн багцын 1000 ш цаасан уутыг төсвийн 2 сая төгрөгөөр худалдан авсан. Ховдын брэнд 5000 багц СББ шалгаруулах уралдаан зарлаж, ОНХСангаас шалгарсан ААН, иргэнд нийт 20 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Орхон аймаг Усны зөн ХХК-ийн үйлдвэрлэсэн 25, 40, 65 литрийн багтаамжтай хуванцар савыг 2 сумын нийт 160 өрхийн хэрэглээнд нийлүүлж, дэмжин ажилласан. Дорноговь аймгийн Сайншанд суманд 4 удаагийн өдөрлөг, сургалт зохион байгуулж, 2050 гаруй иргэнд хуванцар савны талаар гарын авлага тараан, “Нийлэг хальсан уутгүй хот” аян, уриалгыг иргэд, ААНБ-ын дунд зохион байгуулсан. Дархан-Уул аймаг "Төвийн бүсийн үзэсгэлэн худалдаа, Намрын ногоон өдрүүд" арга хэмжээний 2020, 2021 оны оролцогч 200 гаруй ААН-д стандарт, загвар дизайны шаардлага хангасан дотоодын СББ, хаяг шошго хэрэглэхийг зөвлөж, үйлдвэрлэгчидтэй холбож ажилласан. Говь-Алтай аймгийн 350 гаруй иргэдийг хуванцар сав, гялгар уутны хор уршиг, түүнээс татгалзах сургалтад хамруулж, “Хуванцар шанаганаас татгалзъя”, “Гялгар	100%

				уутнаас татгалзъя, даавуун тор урлая” аяныг өрнүүлсний дүнд Хөхморьт сумын нийт өрх 100 хувь хуванцар шанагыг хэрэглээнээс халж, дэлгүүрүүд гялгар уут худалдаалахыг зогсоосон.	
26	3.4. Монгол Улсад үйлдвэрлэх боломжтой сав, баглаа боодлын нэр, төрөл, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаа явуулах, сав, баглаа боодлын үндсэн түүхий эдийг дотооддоо үйлдвэрлэхийг дэмжих, цаас, шил, төмөр сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж, арга замыг судалж шийдвэрлэх;	2017 - 2021		Монгол Улсын хэмжээнд СББ-ын чиглэлээр 50 орчим ААН идэвхтэй үйл ажиллагаа явуулж, 2000 гаруй хүнийг ажлын байраар хангаж байна. Монгол улсын СББ-ын жилийн хэрэгцээ 520 тэрбум гэсэн тойм судалгаа байдаг бөгөөд 65 орчим хувийг импортоор, 35 гаруй хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж байна. СББ-ын дотоодын хэрэгцээг нарийвчлан тодорхойлох, дотоодод үйлдвэрлэх боломжтой түүхий эд, бүтээгдэхүүнийг судлан хөгжүүлэх боломж, арга замыг судлах судалгааны ажлыг гүйцэтгүүлэхээр 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган, зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Ажлын зардал нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарт багтаж байгаа тул гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг хангаж байна. Монголын Хүнсчдийн Холбоо нь ХХААХҮЯ-тай байгуулсан гэрээний дагуу 2021 онд 21 аймаг, Улаанбаатар хотын 4,472 өрхийг хамруулан, SPSS программ ашиглан зориулалтын бус химийн савны хэрэглээний түвшинг тогтоох судалгааг гүйцэтгэж, судалгааны тайланг хүлээлгэн өгсөн. Дархан-уул аймгийн 2021 оны ААН-ийн тооллогоор СББ-ын Сан оргиу ХХК, Монгол лааз ХХК, Таван богдын Шуудайны үйлдвэр, цаасан уут, хаяг шошгын Сайн орших ХХК, Мөнхийн үсэг ХХК, даавуун уут, торны Бурхантын бүтээлч бүсгүйчүүд хоршоо, Глобал коммунитис ОУБ-ын төсөлд хамрагдсан 1 хоршоо, 3 иргэн үйл ажиллагаа явуулж байна. Төв аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүнсний 42, хөнгөний 35 үйлдвэр, цех, 34 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулан “Сав баглаа боодлын хэрэгцээ, шаардлагын судалгаа” хийсэн. Хөвсгөл аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүнс, хоол үйлдвэрлэлийн салбарт ашиглагдаж байгаа сав баглааны нэр төрөл, тоо хэмжээ, хэрэгцээг судалж, судалгааны дүнд үндэслэн цаашид сав баглаа боодлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх эрхзүйн орчин бүрдүүлэх чиглэлийг баримтлан ажиллана. Сав баглаа боодлын худалдаа эрхлэгчдийн мэдээллийг бүртгэлжүүлэх ажлын хүрээнд Баян-Өлгий аймагт импортлогч 41 ААН, худалдаалагч 52 иргэн, Увс аймагт худалдаалагч 9 ААН-ийг бүртгэлжүүлсэн.	90%
27	3.5. Сав, баглаа боодол, хаяг шошгын үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах, бусад	2017 - 2021		- ЗГ-ын 2016 оны 287-р тогтоолоор батлагдсан "Сав баглаа боодол" үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ХХААХҮСайдын 2017 оны А-138 дугаар тушаалаар 4 зорилт, 29 арга хэмжээний хүрээнд төлөвлөн, хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус Үндэсний Зөвлөлийн бүрэлдэхүүнийг ХХААХҮСайдын 2019 оны А-138 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - СББ, хаяг шошгын үйлдвэрлэлийг хөнгөн үйлдвэрлэлийн бусад салбар болон мах, сүүний салбартай хэрхэн хоршин, хамтран ажиллах тухай "Хүнсний	100%

	салбартай хоршин ажиллах боломжийг тодорхойлох үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөлийг төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотой байгуулж үйл ажиллагааг нь дэмжих;			бүтээгдэхүүний савлагаа-брэндинг, маркетинг" сургалтыг 2019 оны 08-р сард зохион байгуулсан. “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2021” нэгдсэн арга хэмжээнд СББ-ын "Об пластик" ХХК, "Финпак" ХХК, "Гофро" ХХК, "Усны Зөн" ХХК зэрэг ААН-үүдийг оролцуулан, аймгуудын ХХААГ-тай хамтран үзэсгэлэнд оролцож буй зориулалтын бус хуванцар саванд сүү, цагаан идээ савласан малчдыг хүнсний зориулалтын хуванцар сав үйлдвэрлэгч "Усны Зөн" ХХК-ийн төлөөлөлтэй холбож ажилласан. Мөн нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээнд зориулан нөөцийн мах бэлтгэх ААН-үүдийг дотоодын СББ-ын үйлдвэрүүдтэй холбон, стандартын шаардлага хангасан уут, СББ-ыг сонгон хэрэглэхийг уриалж, үндэсний үйлдвэрлэгчээ дэмжин ажилласан. - Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний 105 үйлдвэрүүдээс СББ-ын хэрэглээний судалгааг авахад Улаанбаатар хотын ОБ пластик ХХК, Солонго пресс ХХК, Омега ХХК, ЗДМ ХХК, Эко Пак ХХК зэрэг сав баглаа боодлын үйлдвэрүүдээс шуудай, хиамны бүрхэвч хальс, цаасан уут, хаяг шошго, зориулалтын гялгар уутыг татдаг тооцоо гарсан. Хөвсгөл аймгийн талх гурилан бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ үйлдвэрлэж буй үйлдвэрүүд УБ хотын Об Пресс ХХК, Эко Пак ХХК-аас хаяг шошго, бялууны хайрцаг зэрэг сав баглаа боодлоо авч ашиглаж байна. “Адра Монгол” ОУБ-аас Сэлэнгэ аймгийн Зөгийн аж ахуй эрхлэгч хоршоодод стандартын шаардлага хангасан шилэн савнуудыг нийлүүлсэн.	
28	3.6. Олон улсын сав, баглаа боодлын холбоонд гишүүнээр элсэх боломжийг судалж шийдвэрлэх;	2017 - 2021		Дэлхийн Сав баглаа боодлын байгууллага (World Packaging Organization)-ын Удирдах Зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанд холбооны гишүүн 53 орны төлөөлөгчид оролцож, Монголын Сав баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо ГҮТББ-г бүрэн саналын эрхтэй гишүүнээр элсүүлэхийг 97 хувийн саналаар дэмжсэн. Дэлхийн Сав баглаа боодлын байгууллага нь 1968 онд байгуулагдсан ашгийн бус, аль нэг улсын Засгийн газарт хамаардаггүй, үндэсний болон бүс нутгийн сав баглаа боодлын хүрээлэн, холбоод болон бусад хамааралтай корпорациуд, худалдааны холбоодыг нэгтгэсэн байгууллага бөгөөд тус хуралдаанаар ДСБББ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн даргыг сонгох, гишүүнээр элсүүлэх улс орнуудын асуудлыг хэлэлцэв. НҮБ-ын Аж үйлдвэр хөгжлийн байгууллага Европын Холбооны санхүүжилттэй “Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн хүрээнд Дэлхийн Сав баглаа боодлын байгууллага, Монголын Сав баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбоо, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Монголын Хүнсчдийн холбоо хамтран “Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа, боодол ба брэнддинг-маркетинг” сэдэвт олон улсын VI модуль сургалтыг 2019 оны 08 дугаар сарын 27, 29-ний өдөр зохион байгуулсан юм. Энэхүү сургалтын үеэр Дэлхийн сав баглаа боодлын холбооны гишүүн болох асуудлыг хөндөн ярилцсан нь ийнхүү биеллээ оллоо.	100%

29	3.7. Дотоодын сав, баглаа боодол, хаяг шошгыг тогтмол хэрэглэгч, нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгжүүдийг жил бүр шалгаруулж урамшуулдаг болох	2017 - 2021		- Дотоодын СББ, хаяг шошгыг тогтмол хэрэглэгч, нийгмийн хариуцлагатай ААН-ийг урамшуулах "Мөнгөн богц" арга хэмжээг зохион байгуулахаар удирдамж, хөтөлбөр, тушаалын төслийг боловсруулсан боловч, Ковид-19-ийн нөхцөл байдалтай холбоотой тэвчиж болох зардлын ангилалд орж, тус арга хэмжээг зохион байгуулах боломжгүй болсон. Сүхбаатар аймагт "Мөнгөн богц" уралдааны зохион байгуулан 12 төрлийн хайрцаг, сав үйлдвэрлэсэн иргэн, цаасан уут, даавуун торны "Тэлмүүн гүн" ХХК, цагаан идээний хайрцаг үйлдвэрлэсэн малчныг тус тус шалгаруулж, урамшуулсан. Төв аймгийн Аргалант сумын модон торх үйлдвэрлэгч "Мөнгөн богц" шагналыг хүртсэн бөгөөд 10 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн. Өмнөговь аймгийн "Мөнгөн богц" уралдаанд 9 ААН, иргэн оролцсоноос 2 ААН-ийг шалгаруулан урамшуулж, уул уурхай болон хүнсний томоохон худалдаа эрхлэгчидтэй холбож ажилласан. "Алтай түншлэл-2020" үзэсгэлэн худалдаанд оролцсон "Энх таян" ХХК-ийн сүүн бүтээгдэхүүнийг "Шилдэг сав баглаа боодолтой бүтээгдэхүүн"-ээр шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан. "Архангай түншлэл - 2021" арга хэмжээнд "Шилдэг сав баглаа, боодол" номинацыг шалгаруулж, урамшуулсан. "Өвөрхангай-Түншлэл 2021" үзэсгэлэн худалдаанд оролцсон Баян-Өндөр сумын иргэн "Сүү цагаан идээ"-ний хатгамалтай даавуун тор, Арвайхээр сумын иргэн "Тугалхан" ааруулны цаасан уутыг шалгаруулан, урамшуулсан. Дорноговь аймгийн "Намрын ногоон өдрүүд" үзэсгэлэн худалдааны "Шилдэг сав, баглаа боодол" номинацид "Далт мөнгөн шанд" ХХК шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажилласан. Булган аймгийн "Айрагны өдөрлөг"-ийн үеэр айраг, адууны сайхан эдлэл хэрэглэлийг шалгаруулж, 1,2 сая төгрөгөөр шагнаж, урамшуулсан. Хэнтий аймгийн Хэрлэн сумын 4 ААН-д "Нийгмийн хариуцлагатай, дотоодын сав баглаа боодол хаяг шошгыг тогтмол хэрэглэгч" талархлын бичиг гардуулав. Ховдын брэнд 5000 багц СББ шалгаруулах уралдаан зарлаж, ОНХСангаас шалгарсан ААН, иргэнд нийт 20 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100%
----	--	-------------	--	---	------